НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ДОТООД АУДИТЫН АЛБА**
Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж-9, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976) 7010 1388, 7010 1408
Цахим шуудан: contact@internalaudit.ub.gov.mn
Цахим хуудас: www.internalaudit.ub.gov.mn

2022.09.16 № 1/166

танай ______________-ны №______________-т

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ-Т

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 2022 оны 09 дүгээр удирдамжийн дагуу танай байгууллагын 2020 он, 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хүргүүлж байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА Б.ЖАВЗАН

5814839 902201...7 ГСТ7286

115000 322

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

# ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Дотоод аудитын нэр:** 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт
**Хамрагдсан байгууллага:** Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ

**Улаанбаатар хот**

**2022 он**

АГУУЛГА

**ТАНИЛЦУУЛГА** 3

**ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ** 4

**Зорилго** 5

**Хамрах хүрээ** 5

**ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН** 6

*Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар* 6

*Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар* 10

*Зорилт 3. Хөрөнгө оруулалтын талаар* 22

*Зорилт 4. Худалдан авах ажиллагааны талаар* 23

**ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ** 23

**ДҮГНЭЛТ** 26

**ЗӨВЛӨМЖ** 27

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| НИТХТ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| НДАА | Нийслэлийн Дотоод аудитын алба |
| УСНББОУС | Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨТҮГ | Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард улс |
| БНАУ | Бүгд Найрамдах Австри улс |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| НХХААГ | Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газар |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| НӨАУГ | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар |
| УТГ | Улсын төсөвт үйлдвэрийн газар |
| ЗГ | Засгийн газар |
| СХДЗДТГ | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар |

# ТАНИЛЦУУЛГА

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан *"Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"*-ийг хэрэгжүүлэх зорилгоор НИТХТ-ийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдсан байна.

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Нарийны хөндийн Шар хоолойн аманд байрлах 500 орчим га талбайд тариалалт, 1га талбайд төслийн нэгж байрладаг бөгөөд төслийн газарт 90 үнээний загвар ферм, сургалтын байр, малын тэжээлийн сараалж, агуулах, худаг болон газар тариалангийн үйл ажиллагаатай холбоотой бусад тоног төхөөрөмжүүдийг байршуулсан байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь *"Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин хөтөлбөрийг хэрэгжүүлж, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулаг нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах"* чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг байна.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/282 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 10 албан хаагчтайгаар баталсан бөгөөд орон тооны хязгаарт багтаан 10 албан хаагчтайгаар ажилласан байна.

Тус газрын батлагдсан дүрэмд дараах 6 ажил үйлчилгээг эрхлэх чиглэлээр тусгагджээ. Үүнд:

- Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нэвтрүүлэх;
- Дээрх технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Сургалтын төв, дадлагын талбай болон засварын бүхий эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах;
- Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрхи дэвшилтэт технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь Төрийн сан банкны үндсэн үйл ажиллагааны 100200051070, нэмэлт санхүүжилтийн 100200051469 тоот данснуудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж ирсэн байна.

Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоонд нэгдүгээр гарын үсгийг газрын дарга Г.Галдөл 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 16-ныг дуустал, Н.Ууганбаяр нь 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Мөнхдөл 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдах хугацаанд хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

*Өмнөх хяналт шалгалтын талаар:*

Нийслэлийн Дотоод аудитын албанаас тус газрын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар 11 зөвлөмж хүргүүлснээс 8 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, дараах 3 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

| № | Зөвлөмж | Биелэлт | Хувь | Төлөвлөсөн хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг тооцож үнэлэх | Эрсдэлийн үнэлгээг өөрсдийн нөөц бололцоо болон мэргэжлийн байгууллага, дээд шатны харьяа байгууллагыэ зөвлөгөө зөвлөмжийн дагуу боловсруулан ажиллаж байна. | 50 хувь | 2020.12.31 |
| 2 | Төслийн үр дүн, өгөөжийг тооцож нэмэгдүүлэх | НХХААГ болон ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст цаг тухайд нь хянуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллахаар зорьж байна. | 50 хувь | 2020.12.31 |
| 3 | Машин, тоног төхөөрөмжөөр үйлчлэх нэхцлийг бүрдүүлж ажиллах | НИТХ-аар оруулан батлуулахаар НХХААГ-т хүргүүлсэн. | 50 хувь | 2020.12.31 |

Нийслэл дэх Төрийн аудитын газраас тус газрын 2020 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийн 3,667.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас тус газрын 2021 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийн 3,116.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

*Дотоод аудит, хяналт шалгалтын хамрах хүрээний хязгаарлалт:*

Нийслэлийн Засаг даргын захирамжаар бусад байгууллагаас зохион байгуулсан худалдан авах ажиллагаа.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын тайланд дурдсан асуудлыг хамруулаагүй болно. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Нарийний хөндийид байрлах 90 үнээний загварферм дээр очиход мал бэлчээрт гарсан байсан тул тус төслийн нэгжийн мал амьтад дансанд бүртгэлтэй хөрөнгөнд тооллогыг малын тоо толгой бүрээр хийгээгүй, хэсэгчлэн тооллого хийсэн болно.

## ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

**Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 "*Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна*", Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Нийслэлийн Дотоод аудитын алба (НДАА)-ны "Аудит, хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөө", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 2022 оны 09 дүгээр удирдамжийн дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудит, хяналт шалгалтыг Нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит, хяналт шалгалтын хэлтсийн дарга Ч.Гүрбазар мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, ахлах дотоод аудитор /СХШУБ/ Д.Лувсанчимэд багийг ахлан гүйцэтгэлээ.

## Зорилго

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

## Хамрах хүрээ

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

**Дотоод аудит:**

- Байгууллагын засаглал;
- Эрсдэлийн удирдлага;
- Дотоод хяналтын үйл явцыг үнэлэх.

**Хяналт шалгалт:**

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүсэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэх;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

**Шалгуур:**

Дотоод аудит, хяналт шалгалтад дараах шалгуурыг ашигласан болно. Үүнд:

- Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжууд;

- Төрийн албаны тухай болон түүнд нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль тогтоомж;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам";
- УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга;
- Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, журам батлах тухай" 388 дугаар тушаал, мөн уг тушаалд "нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2008 оны 352 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан *"Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"*;
- Дүрэм, журмаар хүлээсэн эрх үүрэг;
- Холбогдох дүрэм, журмууд.

## ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

*ЗОРИЛТ 1. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР*

***Байгууллагын засаглалын талаар:***

*Засаглах удирдлагын талаар*

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тус газар нь дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд үүсгэн байгуулагдсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагдсан эрх зүйн баримт жагсаалт

| № | Огноо | Шийдвэрийн дугаар | Шийдвэр | Агуулга | Шийдвэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2015.07.03 | 121 тоот | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол | Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай | 1. Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсугай. |
| 2 | 2017.05.08 | А/282 | НЗД-ын захирамж | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэх батлах тухай | 1-т Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэх баталсугай. |
| 3 | 2016.02.17 | 9070006100 | Улсын бүртгэлийн гэрчилгээ | Улсын бүртгэлийн гэрчилгээ | Хариуцлагын хэлбэр, Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар |

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, Австри-Монголын нийгэмлэгтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт болон Улаанбаатар хот орчимд эрчимжсэн фермийн аж ахуйг хөгжүүлэх талаар судалгаа явуулах, Улаанбаатар хотын иргэдийн хүнсний хангамжийг сайжруулах концепци боловсруулах талаар санал солилцон, хамтран ажиллахаар Улаанбаатар хотыг төлөөлж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Австри-Монголын бизнесийн хамтын ажиллагааны нийгэмлэгийг төлөөлж Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн ажлын хэсгийн ахлагч нар 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдөр *"Хамтын ажиллагааны санамж бичиг"* байгуулсан байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2020 оны А/07 дугаар тушаалаар газрын даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журмыг баталсан бөгөөд уг журмын 2. *"Зөвлөлийн үйл ажиллагаа ...хэлэлцүүлж, шийдвэрлэхэд чиглэгдэнэ "* гэсэн заалтын дагуу даргын зөвлөл нь 2020 онд 3 удаа, 2021 онд 5 удаа, 2022 оны эхний хагас жилд 2 удаа хуралдан цаг үеийн шинж чанартай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтлөн ажилласан байна.

Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ний А/07 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталжээ.

*Дунд хугацааны стратеги төлөвлөгөө*

Газрын 2019-2022 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны А/27 дугаар тушаалаар батлан тайлагнасан байна.

*Бүтэц, орон тооны талаар*

Нийслэлийн Засаг даргын "Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай" 2017 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн А/282 дугаар захирамжийн хавсралтаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 10 албан хаагчтайгаар баталсан байна.

Хүснэгт 2. Бүтэц, орон тоо

| № | НЗД-ын 2017 оны А/282 дугаар захирамжаар батлагдсан | | 2020-2021, 2022 оны эхний хагас жилд онд |
|---|---|---|---|
| | Албан тушаал | Орон тоо | Ажиллаж байгаа |
| 1 | Дарга | 1 | 1 |
| 2 | Төслийн менежер | 1 | 1 |
| 3 | Нягтлан бодогч | 1 | 1 |
| 4 | Агрономич | 1 | 1 |
| 5 | Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн | 1 | 1 |
| 6 | Механик инженер | 1 | 1 |
| 7 | Нярав | 1 | 1 |
| 8 | Тоног төхөөрөмжийн оператор | 1 | 1 |
| 9 | Фермер | 1 | 1 |
| 10 | Манаач | 1 | 1 |
| | **Нийт** | **10** | **10** |

Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдах хугацаанд батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 10 албан хаагчтай байхаар баталсан бөгөөд батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан ажилласан байна.

Тус газар нь 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаар хөдөө аж ахуйн чиглэлийн албан хаагч 5 буюу 50.0 хувийг эзэлж байна. Үүнээс доктор 1 албан тушаалтан ажилладаг байна.

*Албан тушаалын тодорхойлолт*

Газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/13 дугаар тушаалаар нийт 9 албан тушаалын "Албан тушаалын тодорхойлолт"-ыг боловсруулж, баталсан байна.

*Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн талаар:*

Тус газрын хүний нөөцийн 2018-2020 оны Хүний нөөцийн хөтөлбөрийг газрын даргын 2018 оны А/17 тушаалаар батлан, тайлант онуудын хэрэгжилтийг тайлагнажээ.

*Хүний нөөцийн хөдлөлийн талаар:*

Тус газрын хэмжээнд 2020 оны байдлаар албан тушаалд томилогдсон 1, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч, 2021 оны байдлаар хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч, томилогдсон 2 албан хаагч, 2022 оны эхний хагас жилийн байдлаар албан тушаалаас чөлөөлөгдсөн 3, томилогдсон 3 албан хаагч байна.

*Тушаал шийдвэрийн талаар:*

Тус газрын дарга нь 2020 онд А тушаал 20, Б тушаал 43 , нийт 63 тушаал, 2021 онд А тушаал 15 , Б тушаал 45, нийт 60 тушаал, 2022 онд А тушаал 9 , Б тушаал 26, нийт тушаал 35 тушаал шийдвэр гаргасан байна.

*Дүрмээр хүлээсэн чиг үүргийн талаар:*

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь дүрэмд тусгаснаар Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д заасан Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэр дээр хөдөө аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг байна.

Тус газрын дүрэмд зааснаар дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

2016-2022 оны эхний хагас жилийн байдлаар дүрмээр хүлээсэн үүргийн хувьд дараах байдалтай тайлагнасан байна.

*3.2.1 Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нэвтрүүлэх*

2016 онд Guettler үрлэгчийг ашиглан 10 га талбайд БНХАУ-аас гаралтай 2 төрлийн 6 зүйл олон наст ургамлын холимог үрээр тариалалт хийсэн.

2017 онд тариалалт хийх 10 га талбайг 100 тн орчим бууцаар бордсон. 2017 онд тэжээлийн олон наст таримлын холимог үр тариалах технологийн картыг боловсруулж батлуулсан. Нийлмэл эрдэс бордоо хэрэглэсэн 10 га талбайд БНХАУ-ын 2 төрлийн 6 зүйл олон наст ургамлын холимог үрээр тариалалт хийсэн.

2018 онд туршилтын 150 га талбайд хийлгэсэн хөрсний агрохимийн шинжилгээний дүнг харгалзан бордох талбайг сонгож 5 га газарт бууц цацаж, 10 га талбайг компост бордоогоор бордсон. 2018 онд 74 га талбайд БНАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын тэжээлийн олон наст үр тариалалт хийсэн.

2019 онд "НАТРО" үрээр 6 га-д тариалалт хийсэн.

2020 онд туршилтын талбайд сонголт хийж, нийт 8 га газрыг азот, фосфор, калийн /NPK/ нийлмэл эрдэс бордоогоор 5 га талбайг өнгөрсөн жил бэлтгэсэн компост бордоогоор, 4 га талбайг, мөн 2020 онд БНАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог үрээр 05 дугаар сарын 1 дүгээр арав хоногт багтаан 5 га талбайд, БНХАУ-аас гаралтай 6 зүйл тэжээлийн олон наст ургамлын холимог үртэй хольж 3 га талбайд үрлэгээ хийсэн. Зуны бороо угтуулж 6 дугаар сарын 2 дугаар арав хоногоос эхлэж, Хятад үрээр нийт 24 га-д, БНАУ-аас ирсэн 7 зүйл ургамлын хольцоос бүрдсэн үрийг турших зорилгоор 0.5 га-д тус тус тариалалт хийсэн. Дээрх холимог үрнүүдэд өнгөрсөн жил хийлгэсэн лабораторийн шинжилгээний хариуг үндэслэн, үрийн нормыг 2 дахин ихэсгэж 1 га-д 30 кг-аар тооцож, үрлэгээний ажлыг явуулсан.

2021 онд 10 га талбайг малын өтөг бууцаар бордох ажлыг 5 дугаар сард хийсэн.

Туршилтын 150 га талбайгаас 2022 оны 05 дугаар сарын эхний 5 хоногт хөрсний үржил шимийн үзүүлэлт, тариалалт хийсэн олон наст ургамлын ургалтын байдлыг харгалзан 10 га талбайг сонгон авч 1 га-д 10 тн нормоор тооцож компост бордоо болон бууцаар бордох ажлыг хийсэн.

Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн.

2018-2021 онуудад хүрсэн түвшин

Бэлчээрийг нөхөн сэргээхэд зориулагдсан манай орны хөрс цаг уурын нөхцөлд тохирсон Бүгд Найрамдах Австри Улсад үйлдвэрлэсэн, 2 төрлийн 8 зүйл ургамлаас бүрдсэн олон наст тэжээлийн ургамлын “НАТРО” холимог үрээр 2018 оноос хойш нийт туршилтын 150 га талбайн 88 га-д хөрсийг хөндөхгүй шинэ технологиор тариалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. “НАТРО” холимог үрээс эхний хоёр жил 5-6 зүйл ургамал нутагшиж ургасан, 3 дахь жилээс 5 зүйл үетнээс гадна царгас, хошоонгор гэсэн 2 зүйлийн буурцагтан ургамал ургасан. Дөрвөн жилийн хугацаанд “НАТРО” болон Хятад үр тариалсан 65 га талбайгаас нийт 50600 кг (2021 онд 33500 кг) ургац хураан авч, боож, шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэсэн.



*3.2.4 Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх*

Сүүлийн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авахад 1 га-ын дундаж ургац 450-550 кг байсан бол 2021 оны байдлаар Натро үрээр бордож тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг ургуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлсний дүнд 1 га-ын дундаж ургацыг 1300 кг-д хүргэсэн. Бусад, талбайн ургацыг 830 кг болгож сайжруулсан.

*Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх*

Саалийн үнээнүүдээс харилцан адилгүй сүүний гарцтай 3-4 үнээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор сонгон авч 2019 оны өвөл вакумжуулан боож бэлтгэсэн ногоон тэжээлээр тэжээж сүүний гарцны харьцуулсан судалгааг хийсэн. Судалгааны үр дүнд 2019 онд 2 үнээнд туршихад сүүний гарц дунджаар 47.5 хувь, 2020 онд 3 үнээнд судалгаа явуулахад сүүний гарц 54.3 хувь болж нэмэгдсэн гэж тайлагнасан.

*3.2.5 Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй" байгуулах*

Саалийн үнээний фермийн үйл ажиллагааг тогтворжуулан, саалийн үнээ, тугал болон өсвөр насны үнээнд өдөр бүр стандарт, нормын дагуу өвс тэжээл өгч, усалж байна. 2022 онд 20 үнээ тугалж, шинээр 20 төл хүлээн авсан..

Малын зохиомол хээлтүүлгийн ажлыг 5 үнээнд Нутаг академи ТББ-ын мал зүйч, техникч нартай хамтран, хийж гүйцэтгэсэн. Малын аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын эмчийн үзлэгт байнга оруулах, шаардлагатай вакцинжуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулсан.

Малын удмын сан, НХХААГ, Нутаг академи ТББ-тай хамтран *"Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх"* сертификаттай сургалтыг байгууллагын 90 үхрийн аж ахуй дээр зохион байгуулж явуулсан. Хөдөө орон нутаг болон нийслэлээс тус сургалтанд хамрагдсан 35 хүнд байгууллагын зүгээс нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник, технологи, малын өтөг бууц, хүнсний био хог хаягдлыг ашиглан компост бордоо хийж бэлчээр хадлангийн талбайг бордож, хөрсний үржил шимийг сайжруулж байгаа туршлагаасаа танилцуулсан.

*3.2.6. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрхи дэвшилтэт технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх*

Бүгд найрамдах Солонгос улсын GCS (Global Civic Sharing) төрийн бус байгууллага 60 гаруй малчин гэр бүлийг нэгтгэсэн хоршоо байгуулан ажиллаж байгаа бөгөөд манай байгууллага энэхүү хоршооны 80 га-д тариалсан ногоон тэжээлийг хураан авч, хоршооны гишүүн малчдад түгээх ажлыг хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

*Байгууллагын дотоод хяналтын талаар:*

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тухайн байгууллагад хамаарах заалтууд, байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2020 он, 2021 он, 2022 оны эхний хагас жилийн биелэлтийн явц, үр дүнг НХХААГ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн байна.

*Шалгалтын явцад хийгдсэн ажлын талаар:*

Дотоод аудит, хяналт шалгалтын баг тус газрын СХД-ийн дүүргийн 21 дүгээр хороо, нарийны хөндийн шар хоолойн амд байршилтай хөдөө аж ахуйн загвар фермийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалтай газар дээр нь түүвэрчилсэн хяналтыг хийсэн.

*ЗОРИЛТ 2. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР*

*Санхүүгийн тайлангийн талаар:*

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүнг 2020 онтой харьцуулахад 852,863.3 мянган төгрөг буюу 86.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2020 он | | | 2021 он | |
|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт /3-2/ | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт /5-3/ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - | - | - |
| Авлага | - | - | - | - | - |
| Бараа материал | 125,163.1 | 108,453.1 | (16,709.7) | 110,232.1 | 1,778.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,007,218.9 | 874,122.1 | (133,096.8) | 1,727,202.1 | 853,080.0 |
| Биет бус хөрөнгө | 5,128.6 | 4,113.1 | (1,015.5) | 2,117.6 | (1,995.5) |
| **Нийт хөрөнгө** | **1,137,510.6** | **986,688.5** | **(150,882.1)** | **1,839,551.8** | **852,863.3** |
| Өр төлбөр | - | - | - | - | - |
| Эздийн өмч | 1,137,510.6 | 986,688.5 | (150,882.1) | 1,839,551.8 | 852,863.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, эздийн өмчийн дүн** | **1,137,510.6** | **986,688.5** | **(150,882.1)** | **1,839,551.8** | **852,863.3** |

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Нийслэлийн өмчид барилга, байгууламж бүртгэн авах тухай” А/399 дүгээр захирамж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” З/690 дүгээр тушаалын дагуу 1,023,269.7 мянган төгрөгийн иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуйн барилга, байгууламжийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 110,232.1 мянган төгрөгөөр өссөн нь мал амьтад данстай холбоотой, нас дэвшилтийг бүртгэсэн байна.

Хүснэгт 4. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | |
|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт /3-2/ |
| 1 | 2 | 3 | 4 |
| Мөнгөн хөрөнгө | - | 62,495.0 | 62,495.0 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 110,232.1 | 112,753.6 | 2,521.5 |
| Үндсэн хөрөнгө | 1,727,202.1 | 1,638,590.3 | (88,611.8) |
| Биет бус хөрөнгө | 2,117.6 | 1,679.9 | (437.7) |
| **Нийт хөрөнгө** | **1,839,551.8** | **1,815,518.8** | **(24,033.0)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Эздийн өмч | 1,839,551.8 | 1,815,518.8 | (24,033.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, эздийн өмчийн дүн** | **1,839,551.8** | **1,815,518.8** | **(24,033.0)** |

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн Acolous програмыг ашиглаж бүртгэлийг хөтөлдөг байна. Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/12 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталжээ.

*Мөнгөн хөрөнгийн талаар:*

Тус газрын 2022 оны эхний хагас жилийн байдлаар мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 62,495.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

*Бараа материалын талаар:*

Тайлант 2020 онд нийт 147,954.6 мянган төгрөгийн бараа материалыг нэмэгдүүлснээс 79,024.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 68,613.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 316.9 мянган төгрөгийн материалыг хандиваар авч, нийт 164,664.3 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 79,971.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 77,403.8 мянган төгрөгийн бараа материалыг бусад зарцуулж, 7,288.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 108,453.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 7,288.9 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данс бүртгэлээс хасжээ.

Тайлант 2021 онд нийт 215,866.0 мянган төгрөгийн бараа материалыг нэмэгдүүлснээс 110,130.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 103,889.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 1,845.9 мянган төгрөгийн материалыг бусад авч, нийт 214,087.3 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 29,010.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 181,456.9 мянган төгрөгийн бараа материалыг бусад зарцуулж, 3,620.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 110,232.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/20 дугаар тушаалаар 3,620.0 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данс бүртгэлээс хасжээ.

Тайлант 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 57,801.1 мянган төгрөгийн бараа материалыг нэмэгдүүлснээс 21,735.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 36,065.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, нийт 55,279.6 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 9,814.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 45,465.6 мянган төгрөгийн бараа материалыг бусад зарцуулж, 112,753.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 5. Бараа материалын тайлан /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2020 он | | | | 2021 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | Эцсийн үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | Эцсийн үлдэгдэл |
| 1 | Түүхий эд материал | 27,752.7 | 2,010.7 | 27,986.8 | 1,776.7 | 1,774.0 | 2,524.0 | 1,026.7 |
| 2 | Эм боох материал | 139.2 | 1,375.0 | 1,482.2 | 32.0 | 54.0 | 54.0 | 32.0 |
| 3 | Дуусаагүй үйлдвэрлэл | 23,240.1 | 35,883.7 | 19,070.1 | 40,053.8 | 39,602.9 | 64,286.9 | 15,369.7 |
| 4 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 9,928.0 | 9,928.0 | - | 9,714.0 | 9,714.0 | - |
| 5 | Бичиг хэргийн материал | 729.2 | 1,565.4 | 1,672.1 | 622.4 | 1,034.4 | 1,034.4 | 622.4 |
| 6 | Аж ахуйн материал | 4,113.2 | 9,966.7 | 8,694.4 | 5,385.4 | 13,008.6 | 13,041.3 | 5,352.7 |
| 7 | Сэлбэг хэрэгсэл | 3,578.4 | 3,485.5 | 5,153.9 | 1,910.0 | 2,309.1 | 2,309.1 | 1,910.0 |
| 8 | Түлш, шатах тослох материал | 2,557.7 | 11,056.7 | 13,614.5 | - | 9,392.5 | 9,392.5 | - |
| 9 | Бусад хангамжийн материал | 31,447.1 | 50,422.7 | 54,016.9 | 27,852.9 | 72,051.3 | 65,128.4 | 34,775.8 |
| 10 | Мал амьтад | 31,605.0 | 22,260.0 | 23,045.0 | 30,820.0 | 66,925.0 | 46,602.5 | 51,142.5 |
| | **Нийт дүн** | **125,163.1** | **147,954.6** | **164,664.3** | **108,453.4** | **215,866.0** | **214,087.3** | **110,232.1** |

Хүснэгт 6. Бараа материалын тайлан /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Эцсийн үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | Эцсийн үлдэгдэл |
| 1 | Түүхий эд материал | 1,026.7 | 1,672.5 | 2,667.2 | 31.9 |
| 2 | Эм боох материал | 32.0 | - | - | 32.0 |
| 3 | Дуусаагүй үйлдвэрлэл | 15,369.7 | 26,665.6 | 9,400.0 | 32,635.4 |
| 4 | Бэлэн бүтээгдэхүүн | - | - | - | - |
| 5 | Бичиг хэргийн материал | 622.4 | 202.5 | 210.5 | 614.4 |
| 6 | Аж ахуйн материал | 5,352.7 | 4,605.7 | 3,748.7 | 6,209.8 |
| 7 | Сэлбэг хэрэгсэл | 1,910.0 | 3,104.8 | 3,104.8 | 1,910.0 |
| 8 | Түлш, шатах тослох материал | - | 2,750.0 | 2,750.0 | - |
| 9 | Бусад хангамжийн материал | 34,775.8 | | 23,998.3 | 10,777.5 |
| 10 | Мал амьтад | 51,142.5 | 18,800.0 | 9,400.0 | 9,400.0 |
| | **Нийт дүн** | **110,232.1** | **57,801.1** | **55,279.6** | **112,753.6** |

Түүхий эд материал дансанд бордоо, хятад үр, австри үрийг, дуусаагүй үйлдвэрлэл дансанд үр тариа, малын өвс тэжээл, түлш шатахууныг, хангамжийн материал дансанд бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материал, бусад хангамжийн материалыг бүртгэсэн бөгөөд уг дансдын хөдлөлийн тайлан дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Бараа материалын хөдөлгөөн 2020 он /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2020 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Түүхий эд материал | Дуусаагүй үйлдвэрлэл | Бэлэн бүтээгдэхүүн | Бусад хангамжийн материал | Мал амьтад |
| 1 | Нэмэгдсэн | **2,010.7** | **35,883.8** | **9,928.0** | **50,422.7** | **22,260.0** |
| 1.1 | Үнээс худалдан авсан | 2,010.7 | | 4,964.0 | 43,196.7 | 1,480.0 |
| 1.2 | Хандиваар | | | | 240.0 | |
| 1.3 | Шилжүүлэн авсан | | 35,883.8 | | 6,986.0 | 20,780.0 |
| 2 | Хасагдсан | **27,986.8** | **19,070.1** | **9,928.0** | **54,016.9** | **23,045.0** |
| 2.1 | Зарцуулсан | 4,227.5 | 0.1 | 4,964.0 | 36,503.1 | 5,485.0 |
| 2.2 | Шилжүүлсэн | 23,759.3 | | | | |
| 2.3 | Бусад | | 19,070.0 | 4,964.0 | 13,566.0 | 15,140.0 |
| 2.4 | Актаар устгасан | | | | 3,947.8 | 2,420.0 |

Хүснэгт 8. Бараа материалын хөдөлгөөн 2021 он /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2021 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Түүхий эд материал | Дуусаагүй үйлдвэрлэл | Бэлэн бүтээгдэхүүн | Бусад хангамжийн материал | Мал амьтад |
| 1 | Нэмэгдсэн | **1,774.0** | **39,602.9** | **9,714.0** | **72,051.3** | **66,925.0** |
| 1.1 | Үнээс худалдан авсан | 1,774.0 | | 4,857.0 | 38,977.9 | 40,102.5 |
| 1.2 | Хандиваар | | | | | |
| 1.3 | Шилжүүлэн авсан | | 39,602.9 | 4,857.0 | 32,607.4 | 26,822.5 |
| 1.4 | Бусад | | | | 465.9 | |
| 2 | Хасагдсан | **2,524.0** | **64,286.9** | **9,714.0** | **65,128.4** | **46,602.5** |
| 2.1 | Зарцуулсан | 750.0 | | 4,857.0 | 841.5 | 2,880.0 |
| 2.2 | Шилжүүлсэн | | | | | |
| 2.3 | Бусад | 1,774.0 | 64,286.9 | 4,857.0 | 64,286.9 | 43,722.5 |
| 2.4 | Актаар устгасан | | | | | |

Хүснэгт 9. Бараа материалын хөдөлгөөн 2022 оны эхний хагас жилийн байдлаар

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Түүхий эд материал | Дуусаагүй үйлдвэрлэл | Бэлэн бүтээгдэхүүн | Бусад хангамжийн материал | Мал амьтад |
| 1 | Нэмэгдсэн | **1,672.5** | **26,665.6** | **-** | | **18,800.0** |
| 1.1 | Үнээс худалдан | 1,672.5 | | | | 9,400.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | авсан | | | | | |
| 1.2 | Хандиваар | | | | | |
| 1.3 | Шилжүүлэн авсан | | 26,665.6 | | | 9,400.0 |
| 2 | **Хасагдсан** | **2,667.2** | **9,400.0** | **-** | **23,998.3** | 9,400.0 |
| 2.1 | Зарцуулсан | | | | | |
| 2.2 | Шилжүүлсэн | | | | | |
| 2.3 | Бусад | 2,667.2 | 9,400.0 | | 23,998.3 | 9,400.0 |
| 2.4 | Актаар устгасан | | | | | |

Мал амьтад дансанд 22 үнээ, 10 бяруу, 18 тугал,7 гунж, 6 шүдлэн, нийт 63 малыг бүртгэгдсэн байна. Мал амьтад дансны орлого, зарлагын хөдөлгөөнийг харуулбал:

Хүснэгт 10. Мал амьтан 2020 он

| № | Нэр төрөл | 2020 оны эхний үлдэгдэл | Орлого /нас дэвшилт/ | Зарлага | Акт | 2020 оны эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үнээ | 23 | | 5 | 2 | 16 |
| 2 | Гунж /н.д/ | | | | | 12 |
| 3 | Шүдлэн | 15 | | 2 | 1 | 7 |
| 4 | Бяруу | 7 | | | | 8 |
| 5 | Тугал | 10 | | 1 | 1 | |
| 6 | Тугал -20 | | 16 | 4 | | 12 |
| | **Нийт** | **55** | **16** | **12** | **4** | **55** |

Хүснэгт 11. Мал амьтан 2021 он

| № | Нэр төрөл | 2021 оны эхний үлдэгдэл | Орлого /нас дэвшилт/ | Зарлага | Акт | 2021 оны эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үнээ | 16 | | 3 | 2 | 11 |
| 2 | Үнээ /н.д/ | | | | | 11 |
| 3 | Гунж /н.д/ | 12 | | | 1 | 7 |
| 4 | Шүдлэн | 7 | | | | 6 |
| 5 | Бяруу | 8 | | | 2 | 10 |
| 6 | Тугал -20 | 12 | | | 2 | |
| 7 | Тугал -21 | | 18 | | | 18 |
| | **Нийт** | 55 | 18 | 3 | **7** | **63** |

Хүснэгт 12. Мал амьтан 2022 оны эхний хагас жил

| № | Нэр төрөл | 2022 оны эхний үлдэгдэл | Орлого /нас дэвшилт/ | Зарлага | Акт | 2022 оны эхний хагас жилийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үнээ | 11 | | | | 11 |
| 2 | Үнээ /н.д/ | 11 | | | | 11 |
| 3 | Гунж /н.д/ | 7 | | | | 7 |
| 4 | Шүдлэн | 6 | | | | 6 |
| 5 | Бяруу | 10 | | | | 10 |
| 6 | Тугал -21 | 18 | | | | 18 |
| 7 | Тугал -22 | | 20 | | | 20 |
| | **Нийт** | **63** | 20 | - | - | 83 |

*Үндсэн хөрөнгийн талаар:*

Тайлант 2020 онд үндсэн хөрөнгө дансанд 1,359,644.8 мянган төгрөгийн эхний үлдэгдэл тайлагнаж, 8,390.7 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэгдүүлснээс 3,661.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 4,729.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 142,503.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж 1,368,035.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан.

Хүснэгт 13. Үндсэн хөрөнгийн тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр | 2020 он | | | | | 2021 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагд | ТҮ Элэгдлийн | Эцсийн үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | ТҮ Элэгдлий | Эцсийн үлдэгдэл |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сан | зардал | | | | н зардал | |
| Барилга байгууламж | | | | | | 849,953.3 | | 12,750.5 | 849,953.3 |
| Авто тээврийн хэрэгсэл | 563,363.6 | - | - | 56,551.4 | 563,363.6 | | | 56,551.4 | 563,363.6 |
| Тоног төхөөрөмж | 625,853.9 | 4,999.7 | | 66,248.8 | 630,853.6 | 21,713.8 | 25,128.7 | 83,019.7 | 627,438.7 |
| Тавилга хэрэгсэл | 22,565.9 | 3,391.0 | | 4,086.5 | 25,956.9 | 3,414.9 | | 6,384.5 | 29,371.9 |
| Програм хангамж | 1,020.0 | | | 140.0 | 1,020.0 | | | 359.9 | 1,020.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 141,886.2 | | | 14,600.8 | 141,886.2 | 179,311.3 | | 25,010.6 | 321,197.5 |
| Бусад биет бус хөрөнгө | 4,955.0 | | | 875.5 | 4,955.0 | | | 875.5 | 4,955.0 |
| **Нийт дүн** | **1,359,644.8** | 8,390.7 | - | **142,503.0** | **1,368,035.5** | **1,054,393.4** | **25,128.7** | **163,500.1** | **2,397,300.2** |

Тайлант 2021 онд үндсэн хөрөнгө дансанд 1,368,035.5 мянган төгрөгийн эхний үлдэгдэл тайлагнаж, 1,054,393.4 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэгдүүлснээс 5,995.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 1,023,269.7 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авч, 25,128.7 мянган төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээс авч, 25,128.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 184,952.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж 2,397,300.2 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан.

НЗД-ын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Нийслэлийнн өмчид барилга байгууламж бүртгэн авах тухай захирамжийн хавсралт, НӨАУГ-ын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хөрөнгө бүртгэх тухай А/690 дүгээр тушаал, Газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн А/05 тушаалаар Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Шар хоолойн ам, нарийний хөндийд байрлах Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,023,269.7 мянган төгрөгин өртөгтэй 90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуйн барилга байгууламжийг данс бүртгэлд тусгасан байна. Үүнд: Үхрийн байр, Сургалтын төвийн байр, Материал үр бордооны агуулах, Техникийн агуулах, гараж, засварын байр, Агуулахын барилга гм.

Газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/10 тушаалаар 5,995.0 мянган төгрөгийн өртөг бүхий хамгаалалтын хашааг бүртгэжээ.

Газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/10, 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/01, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/08 тоот тушаалуудаар байгуулагдсан тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан байна.

Хүснэгт 14. Үндсэн хөрөнгийн тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | ТҮ Элэгдлийн зардал | Эцсийн үлдэгдэл |
| Барилга байгууламж | 849,953.3 | | | 10,929.0 | 849,953.3 |
| Авто тээврийн хэрэгсэл | 563,363.6 | | | 28,275.7 | 563,363.6 |
| Тоног төхөөрөмж | 627,438.7 | | | 31,510.0 | 627,438.7 |
| Тавилга хэрэгсэл | 29,371.9 | | | 1,631.0 | 29,371.9 |
| Програм хангамж | 1,020.0 | | | | 1,020.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 321,197.5 | | | 16,265.9 | 321,197.5 |
| Бусад биет бус хөрөнгө | 4,955.0 | | | 437.7 | 4,955.0 |
| **Нийт дүн** | **2,397,300.2** | **-** | **-** | **89,049.5** | **2,397,300.2** |

Тайлант 2022 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгө дансанд 2,397,300.2 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнаж, 89,049.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан байна.

[illegible] төсвөөс 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн [illegible] сарын 11-ны өдрийн 06/6872 дугаар албан [illegible] өдрийн 06/5698 дугаар албан тоотоор Балчээрийн [illegible] нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын 2020-2022 оны [illegible] байна.

[illegible] орон нутгийн төсвөөс санхүүжилт 339,187.7 мянга, үндсэн [illegible] 14,000.0 мянга, нийт 353,187.7 мянган төгрөгийн санхүүжилт [illegible] төсвөөс 326,243.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос [illegible] үнэ төлбөргүй хүлээн авсан 5,046.4 мянга, нийт 351,295.2 мянган [illegible] байна.

[illegible] орон нутгийн төсвөөс санхүүжилт 258,962.8 мянган төгрөгийн [illegible] орон нутгийн төсвөөс 258,962.8 мянга, үндсэн үйл [illegible] 3,640.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,023,269.7 [illegible] 4,860,0 мянга, нийт 1,290,732.5 мянган төгрөгийн орлого [illegible]

[illegible] хагас жилийн байдлаар орон нутгийн төсвөөс санхүүжилт [illegible] ажиллагааны орлогоос 4,756.5 мянга, нийт 191,366.9 мянган [illegible] баталгдсанаас, орон нутгийн төсвөөс 186,610.4 мянга, үндсэн үйл [illegible] 5,540.0 мянга, нийт 192,150.4 мянган төгрөгийн орлого [illegible]

[illegible]

Санхүүжилтийн эх үүсвэр /мянган төгрөгөөр/

| [illegible] | 2020 он | | | 2021 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Эзлэх хувь | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Эзлэх хувь |
| [illegible] санхүүжилт | 339,187.7 | 326,243.8 | 92.8 | 258,962.8 | 258,962.8 | 98.6 |
| [illegible] орлогоос | 14,000.0 | 20,005.0 | 5.7 | - | 3,640.0 | 1.4 |
| [illegible] | 353,187.7 | 346,248.8 | | 258,962.8 | 262,602.8 | |
| [illegible] орлого | | 5,046.4 | 1.5 | | 1,023,269.7 | 79.5 |
| [illegible] орлогын [illegible] | | 351,295.2 | | | 1,285,872.5 | |
| [illegible] ЗД-ын нөөц [illegible] ашиглах нөөц [illegible] | | - | | | - | |
| [illegible] захирагчаас [illegible] төсвөөс доод [illegible] захирагчид [illegible] | | | | | | |
| [illegible] үндсэн үйл [illegible] бий болсон [illegible] | | | | | 4,860,0 | 0.3 |
| [illegible] дүн | | - | | | | |
| [illegible] дүн | - | 351,295.2 | 100 | | 1,290,732.5 | |

[illegible]

Санхүүжилтийн эх үүсвэр /мянган төгрөгөөр/

| Эх үүсвэр | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Эзлэх хувь |
| [illegible] санхүүжилт /орон нутгийн төсвөөс/ | 186,610.4 | 186,610.4 | 97.1 |
| [illegible] орлогоос санхүүжих | 4,756.5 | 5,540.0 | 2.9 |
| [illegible] | 191,366.9 | 192,150.4 | |
| [illegible] авсан орлого | | | |
| [illegible] төлбөргүй орлогын нийт дүн | - | - | |

| | | | |
|---|---|---|---|
| [illegible] нөөц хөрөнгө, ЗД-ын нөөц хөрөнгө түүнтэй [illegible] нөөц хөрөнгөөс | | | |
| [illegible] шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан [illegible] доод шатны төсвийн захирагчид [illegible] хөрөнгө | | | |
| [illegible] байгууллагын үндсэн үйл ажиллагааны [illegible] болсон нэмэлт орлого | | | |
| [illegible] дүн | | | |
| **Нийт дүн** | **191,366.9** | **192,150.4** | |

*[illegible] ажиллагааны орлого:*

[illegible] чиг үүргийн хүрээнд фермийн үйл ажиллагаатай холбоотойгоор [illegible], сүүний орлогоор үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлдэг [illegible].

[illegible] ажиллагааны орлогыг задлан харуулбал дараах байдалтай байна.

[illegible] Үндсэн үйл ажиллагааны орлогын задаргаа

/мянган төгрөгөөр/

| [illegible] | 2020 он | | 2021 он | | 2022 оны эхний хагас жил | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| [illegible] | 14,000.0 | **20,005.0** | - | **8,500.0** | 4,756.5 | **5,540.0** |
| [illegible] | | 4,100.0 | | 4,857.0 | | 1,540.0 |
| [illegible] | | 8,976.0 | | 763.0 | | 4,000.0 |
| [illegible] | | 6,065.0 | | 2,880.0 | | - |
| [illegible] | | 864.0 | | | | - |
| [illegible] | **14,000.0** | **20,005.0** | **-** | **8,500.0** | **4,756.5** | **5,540.0** |

[illegible] 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 142.8 хувь [illegible] төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

[illegible] үйлчилгээний орлого 44.8 хувь буюу 8,976.0 мянга, мал борлуулалт 30.3 [illegible] мянга, сүүний орлого 20.4 хувь буюу 4,100.0 мянга, төмсний орлого 4.3 [illegible] мянга, нийт 20,005.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

[illegible] 2021 онд үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгдөөгүй бөгөөд [illegible] хувь буюу 4,857.0 мянга, мал борлуулалт 33.8 хувь буюу 2,880.0 мянга, [illegible] үйлчилгээний орлого 8.9 хувь буюу 763.0 мянга, нийт 8,500.0 мянган төгрөгийн [illegible] байна.

[illegible] 2022 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагааны [illegible] 116.4 хувь буюу 783.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

[illegible] үйлчилгээний орлого 72.2 хувь буюу 4,000.0 мянга, сүүний орлого 27.8 [illegible] мянга, нийт 5,540.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж тайлагнасан [illegible].

[illegible] орлогыг харилцагч, тоо хэмжээний хувьд задлан харуулвал дараах [illegible].

[illegible] Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлийн задаргаа

/мянган төгрөгөөр/

| [illegible] задаргаа | Гүйцэтгэлийн задаргаа | | |
|---|---|---|---|
| [illegible] | Гүйцэтгэл | Тоо хэмжээ | Тайлбар |
| [illegible] | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Сүүний орлого | [redacted] | [redacted] | Дундаж өртөг 600 төгрөг |
| 2 | Техникийн үйлчилгээ | [redacted] | [redacted] | 5 иргэн, 1 аж ахуй |
| 3 | Мал борлуулалт | [redacted] | [redacted] | Сүү муутай хөгшин үхэр |
| 4 | Төмсний орлого | [redacted] | [redacted] | 1 кг нь 320 төгрөг |
| | Дүн | [redacted] | | |
| 2021 он | | | | |
| 1 | Сүүний орлого | [redacted] | [redacted] | 850 төгрөг |
| 2 | Техникийн үйлчилгээ | [redacted] | [redacted] | 3 Иргэнд |
| 3 | Мал борлуулалт | [redacted] | [redacted] | Хөгшин сүү муутай үхэр |
| | Дүн | [redacted] | | |
| 2022 оны эхний хагас жил | | | | |
| 1 | Сүүний орлого | [redacted] | [redacted] | 905 төгрөг |
| 2 | Техникийн үйлчилгээ | [redacted] | [redacted] | 1 Байгууллага |
| | Дүн | [redacted] | | |

Тус газар нь нэг литр [redacted] 2020 онд 7300 л, 2021 онд 5700 л сүүг борлуулсан [redacted] мянган төгрөгөөр сүүний борлуулалт буурсан байна. [redacted] өмнөх оны мөн үеэс 8,213.0 мянган төгрөгөөр [redacted].

*Үнэ тогтоосон талаар:*

Саалийн гарц, [redacted] байдал зэрэг мөн Фермийн зогсоолын тоо, [redacted] тухайн жилд зарж борлуулдаг байна. Тухайлбал [redacted] үнэлгээгээр, өсвөр нас, тугалыг өртөг тооцох [redacted] үнэ ханшинд нийцүүлэн борлуулдаг бөгөөд тээврийн [redacted] баримталсан гэсэн тайлбарыг өгсөн.

Байгууллагын даргын [redacted] тогтоон борлуулалт, үйлчилгээний орлогыг бүрдүүлжээ. [redacted]

А. Тус газрын даргын [redacted] **зарж борлуулах үнийг** тогтоосон байна. Үүнд:Бэлчээрийн [redacted] ОНӨТҮГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн [redacted] дугаар тушаалын 1. Байгууллагын эргэлтийн хөрөнгөд [redacted] материалын үнэ өртгийн хавсралтад заасны дагуу тогтоож, [redacted] эргэлтийн хөрөнгөнд байгаа зарж борлуулах бараа [redacted] дурьдсаны дагуу тогтоож борлуулсугай, 2.Бараа материалын [redacted] зөвшөөрсүгэй. 3.Орлогыг холбогдох дансанд төвлөрүүлэн [redacted] үүрэг болгосугай. 4. Тушаалын хэрэгжилтэд хяналт [redacted] гэсэн тушаалаар **үнээний** нэг бүрийн үнэ 960.0 [redacted] мянган төгрөгөөр тогтоон борлуулж, орлогыг дансанд [redacted].

Б. Газрын даргын тушаалаар [redacted] **үнийн жагсаалтыг** баталсан байна. Бэлчээрийн [redacted] ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн [redacted] тушаалын 1. Иргэд аж ахуйн нэгжийн захиалгын дагуу газар [redacted] үнийн жагсаалтыг хавсралтаар батлсугай. 2.Энэ тушаал [redacted] оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/13 тоот тушаал [redacted] Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг менежерт [redacted].

*Төсвийн гүйцэтгэлийн талаар:*

Тус газар нь 2020 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт 339,187.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,000.0 мянга, нийт 353,187.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 298,816.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 16,929.0 мянга, нийт 315,745.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 27,426.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус газар нь 2021 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт 258,962.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 258,962.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,794.1 мянга, нийт 260,756.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 4,177.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус газар нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвөөс санхүүжилт 186,610.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,756.5 мянга, нийт 191,366.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 186,610.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,540.0 мянга, нийт 192,150.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 19. Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын талаар /мянган төгрөгөөр/

| Зардлын үзүүлэлт | 2020 он | | | 2021 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **149,864.3** | **149,862.3** | (1.9) | **136,767.9** | **136,584.7** | (183.2) |
| **Нийгмийн даатгалын шимтгэл** | **20,231.6** | **19,148.7** | (1,082.9) | **18,917.7** | **18,398.7** | (518.9) |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **70,456.1** | **48,226.7** | (22,229.4) | **46,056.1** | **46,034.7** | (21.3) |
| **Хангамж, бараа материалын зардал** | **45,272.6** | **34,686.9** | **(10,585.7)** | **25,974.7** | **24,759.6** | (1,215.2) |
| Бичиг хэрэг | 1,565.4 | 1,565.4 | - | 1,000.0 | 1,000.0 | - |
| Тээвэр шатахуун | 37,897.2 | 27,495.4 | **(10,401.8)** | 19,470.3 | 20,049.5 | 579.1 |
| Шуудан холбоо, интернетийн төлбөр | 2,790.0 | 2,606.7 | (183.2) | 4,184.4 | 1,960.1 | (2,224.3) |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 520.0 | 520.0 | - | 1,320.0 | 1,750.0 | 430.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,500.0 | 2,499.3 | (0.7) | - | - | - |
| **Нормативт зардал** | **4,960.0** | **2,440.5** | (2,519.5) | - | - | - |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,500.0 | 1,500.0 | - | - | - | - |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,460.0 | 940.5 | (2,519.5) | - | - | - |
| **Эд хогшил урсгал засварын зардал** | **7,955.0** | **7,951.5** | **3.5** | - | - | - |
| Багаж, техник, хэрэгсэл | 5,700.0 | 5,696.5 | (3.5) | - | - | - |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,255.0 | 2,255.0 | - | - | - | - |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **23,098.1** | **22,079.3** | (1,018.8) | **18,355.5** | **17,945.1** | **(410.4)** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | **5,500.0** | **5,396.3** | (103.7) | 9,500.0 | 9,500.0 | - |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 6,000.0 | 6,000.0 | - | 6,000.0 | 6,000.0 | - |
| Даатгалын үйлчилгээ | 9,467.6 | 9,237.2 | (230.4) | 365.0 | 216.0 | (149.0) |
| Мэдээллийн технологийн үйлчилгээ | 1,500.0 | 1,058.0 | (441.9) | 1,860.0 | 1,860.0 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 295.5 | 267.0 | (28.5) | 295.5 | 245.3 | (50.2) |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 255.0 | 96.0 | (159.0) | 255.0 | 99.0 | (156.0) |
| Газрын төлбөр | 80.0 | 24.8 | (55.2) | 80.0 | 24.8 | (55.2) |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,350.0** | **29,350.0** | - | **12,390.9** | **12,356.1** | (34.7) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 28,800.0 | 28,800.0 | - | 12,390.9 | 12,356.1 | - |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 550.0 | 550.0 | - | | | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Урсгал шилжүүлэг** | **2,000.0** | **2,000.0** | - | **500.0** | **500.0** | - |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 2,000.0 | 2,000.0 | - | 500.0 | 500.0 | - |
| **Нийт зардлын дүн** | **353,187.7** | **315,745.9** | (37,441.8) | **258,962.8** | **260,756.9** | **(1,794.1)** |
| **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **353,187.7** | **315,745.9** | (37,441.8) | **258,962.8** | **260,756.9** | **(1,794.1)** |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 339,187.7 | 298,816.9 | (40,370.8) | 258,962.8 | 258,962.8 | - |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,000.0 | 16,929.0 | 2,929.0 | - | (1,794.1) | (1,794.1) |

Хүснэгт 20. Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын талаар /мянган төгрөгөөр/

| Зардлын үзүүлэлт | 2022 оны эхний хагас жилийн байдлаар | | |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **84,592.2** | **73,599.8** | (10,992.4) |
| **Нийгмийн даатгалын шимтгэл** | **11,420.4** | **9,439.4** | (1,981.0) |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,034.5** | **19,604.0** | (9,430.5) |
| **Хангамж, бараа материалын зардал** | **12,436.0** | **11,257.2** | **(1,178.8)** |
| Бичиг хэрэг | 250.0 | 202.5 | (47.5) |
| Тээвэр шатахуун | 9,600.0 | 9,766.4 | (166.4) |
| Шуудан холбоо, интернетийн төлбөр | 1,146.0 | 1,017.6 | (128.4) |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660.0 | - | (660.0) |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 780,0 | 270.7 | (509.2) |
| **Нормативт зардал** | **1,470.0** | **720.0** | (750.0) |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 750.0 | - | (750.0) |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 720.0 | 720.0 | - |
| **Эд хогшил урсгал засварын зардал** | **4,200.0** | **800.0** | (3,400.0) |
| Багаж, техник, хэрэгсэл | **3,000.0** | **-** | (3,000.0) |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 1,200.0 | 800.0 | (400.0) |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,598.1** | **7,313.6** | (7,284.5) |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 6,000.0 | 6,000.0 | - |
| Даатгалын үйлчилгээ | 6,467.6 | - | - |
| Мэдээллийн технологийн үйлчилгээ | 1,500.0 | 957.0 | (543.0) |
| Тээврийн хэрэгслийн татвар | 295.5 | 254.8 | (40.7) |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 255.0 | 77.0 | (178.0) |
| Газрын төлбөр | 80.0 | 24.7 | (55.2) |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,310.2** | **6,621.3** | (5,688.9) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,310.2 | 6,621.3 | (5,688.9) |
| **Урсгал шилжүүлэг** | **21,305.5.0** | **300.0** | **(21,005.5)** |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэги удаагийн мөнгөн тэтгэмж | 21,005.5 | - | **(21,005.5)** |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 300.0 | 300.0 | - |
| **Нийт зардлын дүн** | **191,366.9** | **192,150.4** | **(783.5)** |
| **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **191,366.9** | **192,150.4** | (783.5) |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 186,610.4 | 186,610.4 | - |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,756.5 | 5,540.0 | (783.5) |

Тайлант 2020 онд нийт зардлын 53.5 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэл, 15.3 хувийг байр ашиглалттай холбоотой, 10.9 хувийг хангамж материалын зардал, 10.1 хувийг тус бүр бараа үйлчилгээний бусад зардал болон урсгал шилжүүлэг, 6.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 2.5 хувийг эд хогшил урсгал засварын зардал, 0.8 хувийг норматив зардал эзэлж байна.

Тайлант 2021 онд нийт зардлын 59.4 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэл, 17.6 хувийг байр ашиглалттай холбоотой, 9.5 хувийг хангамж материалын зардал, 6.9 хувийг тус бүр бараа үйлчилгээний бусад зардал болон урсгал шилжүүлэг, 6.6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр эзэлж байна.

Тайлант 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт зардлын 43.2 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэл, 10.2 хувийг байр ашиглалттай холбоотой, 5.8 хувийг хангамж материалын зардал, 3.8 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 3.4 хувийг тус бүр бараа үйлчилгээний бусад зардал болон урсгал шилжүүлэг, 0.4 хувийг эд хогшил урсгал засварын зардал, 0.3 хувийг норматив зардал эзэлж байна.

Тээвэр шатахууны зардалд Нийслэлийн төр захиргааны авто баазаас албан хэрэгцээний автомашины түрээсийн зардал болон тус газрын тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй бүртгэлтэй 2 трактор, 1 өргүүртэй автомашин, 1 мотоциклын шатахууны зардлыг тайлагнасан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардлаас малын хээл шалгалт, зөвлөх үйлчилгээ болон ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардлуудыг тайлагнажээ.

Тээврийн хэрэгслийн болон хөрөнгийн даатгалыг Мөнх даатгал ХХК-тай даатгалын гэрээ байгуулан зардалд тайлагнасан байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар хог хаягдал зайлуулах, хортон шавьжны устгал хийгдэх ажлууд 7 дугаар сараас хийгдэж эхэлдэгтэй холбоотой зардал хэмнэгдсэн байна. Мөн даатгалын үйлчилгээний зардлын хувьд хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд байгууллага ажлаа дахин төлөвлөн тэвчиж болох зардлын хүрээнд энэ зардлыг түр хойшлуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэн, хэтрүүлэлгүй захиран зарцуулах чиг үүргийн дагуу зардлыг боломжит доод түвшинд барьж ажиллан мөн Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 183 тоот тогтоолын хүрээнд зардлыг хэмнэн, хэтрүүлэлгүй ажилласан байна.

*Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн талаар:*

Тус газар нь 2021 онд 4,860.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 21. Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын талаар /мянган төгрөгөөр/

| № | Зардлын үзүүлэлт | 2020 он | 2021 он | 2022 оны эхний хагас жил |
|---|---|---|---|---|
| 1. | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | - | **3,360.0** | - |
| | Бараа үйлчилгээний зардал | - | 3,360.0 | - |
| 1.3 | **Урсгал шилжүүлэг** | - | **1,500.0** | - |
| | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | - | 1,500.0 | - |
| **2. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | | | | |
| 2.1 | Нэмэлт санхүүжилтийн орлого / үндсэн үйл ажиллагааны орлогоос/ | - | 4,860.0 | - |
| 2.2 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | | |
| 2.3 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан мөнгө | | | |
| 2.4 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны захирагчид хуваарилсан мөнгө | | | |
| | **Нийт зардлын дүн** | - | **4,860.0** | - |

Тус газар нь дээрх зардлыг дараах байдалтай зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 22. /мянган төгрөгөөр/

| № | Зарцуулалт | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Бараа материал | 3,360.0 | 2 аж ахуйн нэгж байгууллагаас бараа материал худалдан авсан байна. |
| 2 | Нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,500.0 | Газрын даргын 2021 оны Б/34, Б/40, Б/41 тоот тушаалаар 3 албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгосон. |

## Зорилт 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

*Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт:*

Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/399 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан нийт 1,023,269.6 мянган төгрөгийн өртөгтэй 90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуйн барилга байгууламж, агуулахын барилгыг тус байгууллагын данс бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Уг шийдвэрийн дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/05 тоот тушаалыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Нарийны хөндийн Шар хоолойн аманд байрлах иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй, агуулахын барилгыг холбогдох дансанд бүртгэлд тусгасан байна.

1 га талбай бүхий фермерийн цогцолбор аж ахуй



Хүснэгт 23. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байдал

/мянган төгрөгөөр/

| № | Барилга байгууламжийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Биет хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үхрийн байр | 2019 | м2 | 510 | 909.2 | 463,712.4 |
| 2 | Сургалтын төвийн байр | 2019 | м2 | 80 | 1,534.3 | 122,742.0 |
| 3 | Материал үр бордооны агуулах | 2019 | м2 | 55 | 565.1 | 31,079.7 |
| 4 | Техникийн агуулах, гараж, засварын байр | 2019 | м2 | 60 | 1,030.5 | 61,830.8 |
| 5 | Тэжээлийн саравч | 2019 | м2 | 144 | 261.3 | 37,620.2 |
| 6 | Гадна шугам сүлжээ | 2019 | м | 296 | 350.7 | 103,819.5 |
| 7 | Халаалтын тоног төхөөрөмж | 2019 | ш | 16 | 1,413.3 | 22,613.4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Гадна тохижилт | 2019 | м2 | 520.4 | 63.2 | 32,873.9 |
| | | | **Дүн** | | | **876291.9** |
| 9 | Агуулахын барилга | 2021 | м2 | 400 | 332.4 | 132968.4 |
| 10 | Дотор цахилгааны шугам | 2021 | у/м | 1100 | 9.1 | 10009.7 |
| 11 | Гадна цахилгааны шугам | 2021 | у/м | 135 | 29.6 | 3999.7 |
| | | | **Дүн** | | | **146977.8** |
| | | | **Нийт** | | | **1023269.7** |

*ЗОРИЛТ 4. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР*

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-т 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан зардал нь төсөвт өртөг босго үнээс даваагүй шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

**ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ**

1. Тус байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг *"төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар"* гэж хольж бүртгэсэн, мөн байгууллагын тамга, тэмдэг нь "УТҮГ" гэсэн байна.
   Энэ нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хүрлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ байгуулах тухай 121 дүгээр тогтоолоор баталсан дүрэмд "ОНӨТҮГ" байхаар тусгасан. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7. Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд 7.1.8. *"төрийн байгууллага, албан газар"*; 7.1.9. *"улсын төсөвт үйлдвэрийн газар"*; заалттай нийцэхгүй байна.
2. Тус газар нь шинээр томилогдсон 2 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй байна. Үүнд:Тоног төхөөрмжийн оператор албан тушаалд 2022 оны 04 дүгээр 01-ний өдрөөс томилогдсон Ганболд, хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнээр 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс томилогдсон Отгонжаргал нартай хөдөлмөрийн гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй байна. 2023 онд он гараад шинэ хуулийн дагуу шинэчлэн байгуулна гэсэн тайлбарыг хүний нөөц өгсөн. Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын Гурав. Ажилд авах, ажлаас чөлөөлөх 3.1.3. Хүний нөөцийн мэргэжилтэн танилцуулсан иргэдээс тухайн ажил албан тушаалд тэнцсэн иргэнтэй МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл.Хөдөлмөрийн гэрээ, түүний талууд 47.1. *"Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна"*. заалтыг мөрдөөгүй.
3. Холбогдох дээд байгууллагаар үнэ тарифыг батлуулаагүйгээр тус газрын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар байгууллагын эргэлтийн хөрөнгөд байгаа зарж борлуулах бараа материалын өртөгийн үнийг, 2022 ОНЫ А/05 дугаар тушаалаар Иргэд аж ахуйн нэгжийн захиалгын дагуу газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх үнийг тогтоосон байна. Энэ нь Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан тус газрын дүрмийн 5.7. *"Дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана"*, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай 21 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 21.1.5. *"хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд ..., үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан ... хураамжийн хувь хэмжээг тогтоох"*; Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2020 оны 12 сарын 24 өдөр шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 35.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.10. *"хуулиар тогтоосон хязгаарын*

*хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;"* заалтуудтай нийцэхгүй байна.

4. А. 2020 оны эхний хагас жилд Албан хаагчдын Ур чадварын нэмэгдэл хөлсийг олгох тушаалд ЗГ-ын тогтоолыг үндэслээгүй байна. Газрын даргын 2020 оны Б/02,Б/03, Б/06, Б/12,Б/14, Б/17 дүгээр тушаалуудад даргын 2017 оны Б/09 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ур чадварын нэмэгдэл олгох тухай" журмыг үндэслэсэн.

   Б. 2021 онд Ажилд томилох тухай тушаалд ЗГ-ын 2019 оны Төрийн албан хаагчийн эхний хагас жилд Албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн батлах тухай 472 дугаар тогтоолыг үндэслээгүй. /Б/11,Б/12, Б/14, Б/12,Б/18, Б/26, Б/29, Б/36 дугаар тушаалууд./

   В.2022 оны А, Б тушаалд хуулийн заалтыг буруу үндэслэсэн. Тухайлбал: Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 заалтыг үндэслэсэн. Уг заалт шинэчлэгдсэн заалтад байхгүй. Тухайлбал:Ажилд томилох болон, чөлөөлөх тушаалуудад Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалтыг үндэслэсэн, мөн хөдөлмөрийн тухай хуулийн хуучин заалтыг үндэслэсэн, мөн албан тушаалтныг Ажлаас чөлөөлөхдөө хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг үндэслээгүй. Үүнд;2022 оны А тушаал 3, Б тушаал 8 тушаалд хүчинтөгөлдөр бус хуулийн заалт үндэслэсэн.

   Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг үндэслээгүй. ЗГ-ын 2019 оны Төрийн албан хаагчийн эхний хагас жилд Албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн батлах тугай 472 дугаар тогтоолыг үндэслээгүй. Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан тус газрын дүрмийн 5.7. "Дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана" заалтуудыг мөрдөөгүй.

5. Тус байгууллагад фермерийн зориулалттай ашиглагдаж байгаа боловч өөр байгууллагын эзэмших эрх шилжигдээгүйгээс бүртгэлд тусгаагүй газрын талаар

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд Фермерийн цогцолбор бүхий аж ахуйн 1га талбайг фермерийн зориулалтаар ашиглаж байгаа боловч тус газарт газрын эрх шилжиж ирээгүйгээс данс бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4.*"үнэн зөв байх"* заалтыг мөрдөөгүй байна.Үүнд:

СХДЗДТГ-т НЗД-ын 2015 оны А/432 дугаар захирамжаар Нарийны хөндийн шар хоолойн ам 10000 м кв газрыг фермерийн зориулалтаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн 000438901 дугаартай Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ олгогдож бөгөөд 2030 оны 10 дугаар сарын 29-нийг хүртэл хугацааг сунгасан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 24. /мянган төгрөгөөр/

| | Дугаар | Байгууллагын нэр | Шийдвэрийн огноо | Нэгж талбар | Хэмжээ м.кв | Хугацаа | Зориулалт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 000438901 | СХДЗДТГ | СХД-ийн ЗД-ын 2015.10.29-ний А/432 | 1861934455 2736 | 10000 | 5жил 2020.10.29 | Фермер Нарийны ар шар хоолойн ам-Эзэмших |
| 2 | Э-2201027614 | | 01116-А/329/2021 | 1801916109 | 9907 | 2030.10.29 | |

СХД-ийн Газар зохион байгуулалтын албанаас газрын хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбоотой тус газарт шилжүүлж ирээгүй ирээгүй гэсэн тайлбарыг өгсөн болно.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь тус газрын төлбөрийг 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилд тухайн он тус бүрт 24.7 мянган төгрөгийг төлсөн байна.



6. Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн талаар

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд байрлах Фермерийн болон тариалангийн зориулалтаар ашиглагдаж байгаа нэг бүрийн үнэ нь 29,425.8 мянга, нийт 2 ширхэг 58,851.6 мянган төгрөгийн өртөгтэй гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4.*"үнэн зөв байх"* заалтыг мөрдөөгүй байна.

Фермийн худаг



Гүний худаг



7. Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт, гарын үсгийн бүрдэл дутуу нийт 315.4 мянга төгрөгний шатахуун зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн13.5. *"Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно."* заалтыг бүрэн мөрдөөгүй. Тухайлбал:
   Тус газар нь 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн49-61 УНГ дугаартай өргүүрт машинд 95.6 л буюу 1 л түлшний үнэ 3300 төгрөг, нийт 315.4 мянган төгрөгний шатахууны зарцуулалт.
8. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны А/121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дүрэмд тусгагдсан чиг үүрэгтэй холбоотой дараах заалтууд бүрэн хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 25. Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дүрмийн хэрэгжилт хангалтгүй заалт

| № | Байгууллагуудын дүрэмд чиг үүргийн заалтууд | Тайлбар |
|---|---|---|
| | **Гурав. Газар нь дараах ажил үйлчилгээг эрхэлнэ.** | |
| 1. | *3.2.1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт технологийг турших, нэвтрүүлэх* | Бүгд Найрамдах Австри Улсаас нийлүүлэх НАТРО холимог үрийг худалдан авах хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс 2018 оноос эхлэн уг үрээр туршилтын тариалалт хийж эхэлсэн бөгөөд жил бүрийн төсөвт натро холимог үрийн зардал төсөвт тусгагдаагүйгээс нийт 150 га талбайд тариалах боломж бүрдээгүй бөгөөд уг хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй, бодит үр дүн харагдахгүй байна. |
| 2. | *3.2.4. Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх* | Сүүний гарцыг 2020 онд 3 үнээнд судалгаа явуулан 54.3 хувь нэмэгдсэн гэж тайлагнасан бөгөөд 2021 он, 2022 оны эхний хагас жилд сүүний гарцын талаар хийсэн бодитой судалгаа байхгүй байна. Бодитоор газар дээр нь шалгахад үнээний саалтуурыг ашигладаггүй байна. |
| 3. | *3.2.6. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрхи дэвшилтэт технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх* | Бодитой хэрэгжсэн ажил тайлагнаагүй байна. |

## ДҮГНЭЛТ

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь НИТХТ-ийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан *“Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”*-ийн хүрээнд төслийн нэгжийн үйл ажиллагааг 1 үе шаттай 5 жил байхаар баталсан болович анхны хөтөлбөрийн дагуу хийх ажлууд хойшлогдсон. Тухайлбал: Бүгд Найрамдах Австри Улсаас нийлүүлэх НАТРО холимог үрийг худалдан авах хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс 2018 оноос эхлэн уг үрээр туршилтын тариалалт хийж эхэлснээр төслийн хугацаанд ажлууд бүрэн хэрэгжээгүй, зорилтууд хэрэгжиж байгаа гэх болович үр ашгийн талаарх тооцоо судалгаа хангалтгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад холбогдох байгууллагууд үр дүнг дүгнэж ажиллаагүй байгаа нь төслийн өгөөжийг бууруулах эрсдэлтэй байна.

Тайлант хугацаанд дээд газрын шийдвэрээс шалтгаалан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2 ширхэг гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд Фермерийн цогцолбор бүхий аж ахуйн 1га талбайг фермерийн зориулалтаар ашиглаж байгаа болович тус газарт газрын эрх шилжиж ирээгүйгээс данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Өөрийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үхэр борлуулах үнийг тогтоон, борлуулсан байна.

Тоног төхөөрөмжийн ашиглалтын хувьд үнээний саалтуурыг ашигладаггүй, гар аргаар саамж байгаа нь төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.

Үр тариа тариалах ажлын хүрээнд бэлчээрийг нөхөн сэргээхэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орон нутгийн хөрс, цаг уурын нөхцөлд тохирсон шинэ сортын ногоон тэжээлийн

тarимлыг нутагшуулан, тариалалтыг хийсэн боловч нийт га талбайг бүрэн хамруулаагүй байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын удирдлага нь Монгол улсын Сангийн сайдын 2017 оны тушаалаар 347 дугаар тушаалаар баталсан *“Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”*, 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал”-ыг санхүү бүртгэлийн үйл ажиллагаандаа ашигладаг байна.

Тус газар нь 2020 он, 2021 он, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад тодруулгыг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, эрх зүйн актын хүрээнд УСНББОУС-аар тайлагнаж, татвар нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна.

Тайлант жилийн батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн дагуу бэлэн бусаар төлбөр тооцоог хийж, худалдан авсан хөрөнгийг тухай бүр данс бүртгэл, тайлан тэнцэлдээ тусгасан байна.

Батлагдсан төсвийг хэмнэн, хэтрүүлэлгүй ажилласан байна. Тус газар нь тайлант онуудад авлага, өр төлбөргүй ажилласан байна.

Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан хугацаанд цалин хөлсийг санхүүгийн программаар тооцоолон, цаг хугацаанд нь олгон тайлагнасан байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-т хийсэн дотоод аудит, хяналт шалгалтаар байгууллагын засаглалтай холбоотой илэрсэн асуудалд 5 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 59,167.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг цаашид давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгч байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

## ЗӨВЛӨМЖ

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн асуудалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг хуульд заасны дагуу болгох;
2. Шинээр томилогдсон ажилтантай Хөдөлмөрийн гэрээг байгуулж хэвших;
3. Холбогдох эрх бүхий байгууллагаар үнэ тарифыг батлуулах, санал хүргүүлэх;
4. Ур чадварын нэмэгдлийг олгохдоо ЗГ-ын тогтоолыг үндэслэж шийдвэр гаргах, ЗГ-ын тогтоолыг үндэслэж цалин хөлсийг тогтоох шийдвэр гаргаж байх, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн болон хүчин төгөлдөр хуулийн заалтыг мөрдөх;
5. Ашиглаж байгаа газрын эзэмших эрхийн нэрийг тус байгууллагын нэр дээр шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх ажил зохион байгуулах;
6. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд байрлах Фермерийн болон тариалангийн зориулалтаар ашиглагдаж байгаа нэг бүрийн үнэ нь 29,425.8 мянга, нийт 2 ширхэг 58,851.6 мянган төгрөгийн өртөгтэй гүний худгийг данс бүртгэлд тусгах;
7. Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн, үнэн зөв хөтлөх;
8. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг нийслэлийн Дотоод аудитын албанд ирүүлэхийг мэдэгдэж байна.

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Б.ЖАВЗАН

ХЯНАСАН:
АУДИТ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ч.ГҮРБАЗАР

БЭЛТГЭСЭН:
АУДИТ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ ДОТООД АУДИТОР /СХШУБ/ Д.ЛУВСАНЧИМЭД

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН
НЭГЖ ОНӨТҮГ-ЫН ДАРГА Н.УУГАНБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ Ц.МӨНХДӨЛ

Ажлын баримт 3000

## БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ-Т ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

/мян.төг/

| № | Илэрсэн асуудлын утга | Холбогдох хууль тогтоомж | Нийт илэрсэн асуудал | Үүнээс | | | Өгсөн зөвлөмжийн утга |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Акт | Албан шаардлага | Зөвлөмж | |
| Засаглалтай холбоотой зөрчил | | | | | | | |
| 1 | Тус байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг "төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэж хольж бүртгэсэн, мөн байгууллагын тамга, тэмдэг нь "УТҮГ" гэсэн байна. | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ байгуулах тухай 121 дүгээр тогтоолоор баталсан дүрэмд "ОНӨТҮГ" байхаар тусгасан. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7. Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд 7.1.8.төрийн байгууллага, албан газар;<br>7.1.9.улсын төсөвт үйлдвэрийн газар; заалттай нийцэхгүй байна. | | | | + | Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг хуульд заасны дагуу болгох |
| 2 | Тус газар нь шинээр томилогдсон 2 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй байнаҮүнд:Тоног төхөөрмжийн оператор албан тушаалд 2022 оны 04 дүгээр 01-ний өдрөөс томилогдсон Ганболд, хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнээр 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс томилогдсон Отгонжаргал нартай хөдөлмөрийн гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй байна. 2023 онд он гараад шинэ хуулийн дагуу шинэчлэн байгуулна гэсэн тайлбарыг хүний нөөц өгсөн. | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын Гурав.Ажилд авах, ажлаас чөлөөлөх 3.1.3. Хүний нөөцийн мэргэжилтэн танилцуулсан иргэдээс тухайн ажил албан тушаалд тэнцсэн иргэнтэй МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл.Хөдөлмөрийн гэрээ, түүний талууд 47.1. "Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна". заалтыг мөрдөөгүй. | | | | + | Шинээр томилогдсон ажилтантай Хөдөлмөрийн гэрээг байгуулж хэвших |
| 3 | Холбогдох дээд байгууллагаар үнэ тарифыг батлуулаагүйгээр тус газрын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар байгууллагын эргэлтийн хөрөнгөд байгаа зарж борлуулах бараа материалын өртөгийн үнийг, 2022 ОНЫ А/05 дугаар тушаалаар Иргэд аж ахуйн нэгжийн захиалгын дагуу газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх үнийг тогтоосон байна. | Энэ нь Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан тус газрын дүрмийн 5.7. "Дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана", Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай 21 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 21.1.5. "хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд ..., үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан ... хураамжийн хувь хэмжээг тогтоох"; Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2020 оны 12 сарын 24 өдөр шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 35.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:35.1.10. "хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;" заалтуудтай нийцэхгүй байна. | | | | + | Холбогдох эрх бүхий байгууллагаар үнэ тарифыг батлуулах, санал хүргүүлэх; |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | А. 2020 оны эхний хагас жилд Албан хаагчдын Ур чадварын нэмэгдэл хөлсийг олгох тушаалд ЗГ-ын тогтоолыг үндэслээгүй байна. Газрын даргын 2020 оны Б/02,Б/03, Б/06, Б/12,Б/14, Б/17 дугээр тушаалуудад Даргын 2017 оны Б/09 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ур чадварын нэмэгдэл олгох тухай журмыг үндэслэсэн. Б.2021 онд Ажилд томилох тухай тушаалд ЗГ-ын 2019 оны Төрийн албан хаагчийн эхний хагас жилд Албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн батлах тухай 472 дугаар тогтоолыг үндэслээгүй. Б/11,Б/12, Б/14, Б/12,Б/18, Б/26, Б/29, Б/36 дугаар тушаалууд. В.2022 оны А, Б тушаалд хуулийн заалтыг буруу үндэслэсэн. Тухайлбал: Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 заалтыг үндэслэсэн. Уг заалт шинэчлэгдсэн заалтад байхгүй. Тухайлбал:Ажилд томилох болон, чөлөөлөх тушаалуудад Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалтыг үндэслэсэн, мөн хөдөлмөрийн тухай хуулийн хуучин заалтыг үндэслэсэн, мөн албан тушаалтныг Ажлаас чөлөөлөхдөө хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг үндэслээгүй. Үүнд;2022 оны А тушаал 3, Б тушаал 8 тушаалд хүчингүй болсон хуулийн заалт үндэслэсэн. | Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг үндэслээгүй. ЗГ-ын 2019 оны Төрийн албан хаагчийн эхний хагас жилд Албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн батлах тугай 472 дугаар тогтоолыг үндэслээгүй. Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан тус газрын дүрмийн 5.7. "Дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана" заалтуудыг мөрдөөгүй. | | | | + | Ур чадварын нэмэгдлийг олгохдоо ЗГ-ын тогтоолыг үндэслэж шийдвэр гаргах, ЗГ-ын тогтоолыг үндэслэж цалин хөлсийг тогтоох шийдвэр гаргаж байх, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн болон хүчин төгөлдөр хуулийн заалтыг мөрдөх |
| 5 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дүрмийн дараах заалтууд хэрэгжилт хангалтгүй байна. 3.2.1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт технологийг туршиж, нэвтрүүлэх. Бүгд Найрамдах Австри Улсаас нийлүүлэх НАТРО холимог үрийг худалдан авах хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс 2018 оноос эхлэн уг үрээр туршилтын тариалалт хийж эхэлсэн бөгөөд жил бүрийн төсөвт натро холимог үрийн зардал төсөвт тусгагдаагүйгээс нийт 150 га талбайд тариалах боломж бүрдээгүй бөгөөд уг хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй, бодит үр дүн харагдахгүй байна. 3.2.4. Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх.Сүүний гарцыг 2020 онд 3 үнээнд судалгаа явуулан 54.3 хувь нэмэгдсэн гэж тайлагнасан бөгөөд 2021 он, 2022 оны эхний хагас жилд сүүний гарцын талаар хийсэн бодитой судалгаа байхгүй байна. Бодитоор газар дээр нь шалгахад үнээний саалтуурыг ашигладаггүй байна. 3.2.6. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрхи дэвшилтэт технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх. Бодитой хэрэгжсэн ажил тайлагнаагүй байна. | Дүрмийн 3.2.1, 3.2.4, 3.2.6 заалтууд бүрэн хэрэгжээгүй. | | | | + | Дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил | | | | | | |
| 6 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ ньСонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд Фермерийн цогцолбор бүхий аж ахуйн 1га талбайг фермерийн зориулалтаар ашиглаж байгаа боловч тус газарт газрын эрх шилжиж ирээгүйгээс данс бүртгэлд тусгагдаагүй байна. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4."үнэн зөв байх" зааltыг мөрдөөгүй байна. | | | | + | Ашиглаж байгаа газрын эзэмших эрхийн нэрийг тус байгууллагын нэр дээр шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх ажил зохион байгуулах |
| 7 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд байрлах Фермерийн болон тариалангийн зориулалтаар ашиглагдаж байгаа нэг бүрийн үнэ нь 29,425.8 мянга, нийт 2 ширхэг 58,851.6 мянган төгрөгийн өртөгтэй гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй байна. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4."үнэн зөв байх" зааltыг мөрдөөгүй байна. | 58851.6 | | | 58851.6 | Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн шар хоолойн аманд байрлах Фермерийн болон тариалангийн зориулалтаар ашиглагдаж байгаа нэг бүрийн үнэ нь 29,425.8 мянга, нийт 2 ширхэг 58,851.6 мянган төгрөгийн өртөгтэй гүний худгийг данс бүртгэлд тусгах |
| 8 | Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт, гарын үсгийн бүрдэл дутуу нийт 315.4 мянга төгрөгний шатахуун зарцуулсан. Тухайлбал:Тус газар нь 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн49-61 УНГ дугаартай өргүүрт машинд 95.6 л буюу 1 л түлшний үнэ 3300 төгрөг, нийт 315.4 мянга төгрөгний шатахууны зарцуулалт | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. | 315.4 | | | 315.4 | Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн, үнэн зөв хөтлөх |
| | Нийт | | 59,167.0 | - | - | 59,167.0 | |

Илэрсэн асуудал бүрээр өгөгдсөн зөвлөмж тус бүрд холбогдох тайланг нийслэлийн Дотоод аудитын албанд хугацаандаа ирүүлэхийг мэдэгдэж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудалтай танилцаж, хүлээн зөвшөөрсөн:

Дарга Н.УУГАНБАЯР

Тамга УЛААНБААТАР ХОТ БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ҮТҮГ 6046231 1116117863

Нягтлан бодогч Ц.МӨНХДӨЛ